



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/195

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нийтээр дагаж мөрдөх журам болон аймгийн Засаг даргын "Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар хориглох тухай" А/167 дугаар захирамжийг хэрэгжүүлж ажиллаагүй Хэрлэн сумын "Тунсаг-Эрдэнэ" ХХК болон "Бүс чандмань" ХХК-тай сонсох ажиллагаа зохион байгуулах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн Н.Ган-Адъяаг томилсугай.

2. Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу хийж гарсан саналыг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, худалдаа үйлчилгээ аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн Н.Ган-Адъяад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА